



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/22

Баянсайр

Засаг даргын нөөц хөрөнгөөс
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны А/27 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2024 оны 1 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сум нь зудын эрсдэл “Их” гэж үнэлэгдэн хаваржилт хүндэрч байгаа тул гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд Баян-Өлгий аймгаас сумын аюулгүй нөөцөд болон малчдад тэжээл, хорголжин татан нийлүүлэх үнэ, тээврийн зардалд 27,900,000 (Хорин долоон сая есөн зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсугай.

2.Тус хөрөнгийн зарцуулалтыг журмын дагуу зарцуулж тайлагнахыг төсвийн шууд захирагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Наранбаатар), Санхүүгийн албаны дарга (Б.Гэрэлмөнх), Тамгын газрын нягтлан бодогч (Д.Анхтуяа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

С.ЭНХТӨР

642301241